МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 12 сарын 14 өдөр Дугаар А/564 Мандалговь

Төсөл санхүүжүүлэх тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, 58 дугаар зүйлийн 58.2.1, 58.2.17 дахь заалт, "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авх тухай хууль"-ийн 8.1.2, Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2017 оны 25 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн 17 хуралдааны тэмдэглэлийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Тэмээн сүргийн үүлдэр угсааг сайжруулах, тоо толгойг өсгөх, говийн малчид, тэмээчдийн туршлагыг солилцуулах, тэдний хөдөлмөрийг үнэлэх, алдаршуулах, дотоод гадаадын зочид, жуулчдын сонирхлыг татах чиглэлд төрөөс явуулж буй бодлого, чиглэлийн талаар хэлэлцэж, тэмээчдийнхээ санал бодлыг сонсох зорилгоор зохион байгуулагдаж байгаа "Тэмээний баяр" төслийг "Хөдөө аж ахуй хоршоологчдын холбоо" ТББ-аар гүйцэтгүүлсүгэй.

Хоёр. Төслийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд "Хөдөө аж ахуй хоршоологчдын хоршоо" ТББ-д шаардлагатай дэмжлэг, туслалцаа үзүүлж хамтран ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), Хүнс, хөдөө аж ахуйн газар (Б.Мөнхжаргал)-д үүрэг болгосугай.

Гурав: Төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах 6.500.000 (зургаан сая таван зуу) төгрөгийг аймгийн 2018 оны ОНХС-ийн "Хөтөлбөр арга хэмжээ"-ний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (А.Ганбат)-т, гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА О.БАТ-ЭРДЭНЭ

488010722